

1.3 Анги удирдсан багшид хэрэглэгчийн эрх хуваарилах

1.3. Анги удирдсан багшид хэрэглэгчийн эрх хуваарилах

Хэрэглэгчийн эрх хуваарилахаас өмнө системд дараах үйлдлийг хийсэн байх ёстой.

1. Багшийг **Боловсролын Удирдлага** -ын системд **Багш, ажилтан** модулиар жагсаалтанд нэмж оруулсан байх. (Багш, ажилтан нэмэх үйлдлээр)

2. Багшийг **Боловсролын Удирдлага** -ын системийн **Анги, бүлэг** модульд (**бүртгэгдэж үүссэн анги бүлгийн**) АУБ-аар оноож өгсөн байх. (Удирдсан багшийг нэмж өгснөөр жагсаалтад тухайн анги бүлгийн харгалзах удирдсан багш хэсэгт багшийн нэр орж ирсэн байх)


Хэрэглэгчийн эрх (багшийн эрх) хуваарилах үйлдлийг дараах дарааллын дагуу хийнэ.

1. Хэрэглэгчийн цэс рүү орж **хэрэглэгчийн эрх** үйлдлийг сонгоно.

2. **Хэрэглэгчийн эрх** цонхны **багшийн эрх** табыг сонгоно.

3. Багшийн эрх бүрийн ард тухайн эрхийг ашиглах эрх бүхий багшийн овог, нэр, регистрийн дугаарыг сонгож бүртгэж хадгална.

4. Сонгосон багшид хэрэглэгчийн эрх шинээр үүсэх бөгөөд нэвтрэх нууц үгийг менежер үүсгэж АУБ нарт тарааж өгнө.



Боловсролын удирдлага цонхны баруун дээд хэсэгт байрлах хэрэглэгчийн нэрийн арын доош харсан сум дээр дарж (хэрэглэгчийн цэс) **хэрэглэгчийн эрх** үйлдлийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

Хэрэглэгчийн эрх **Багшийн эрх** Шалгалтын эрх

Шинэчлэх

Хэрэглэгчийн нэр	Нууц үг	Нэр	Овог	Албан тушаал	
ES3510562024	*****	Шинэчлэх		Багш, монгол хэл, у...	Багш сонгох
ES3510566411	*****	Шинэчлэх		Багш, математикийн	Багш сонгох
ES3510565236	*****	Шинэчлэх		Багш, бага ангийн /...	Багш сонгох
ES3510566350	*****	Шинэчлэх		Багш, бага ангийн /...	Багш сонгох
ES3510566357	*****	Шинэчлэх		Багш, мэдээлэл зүйн	Багш сонгох
ES3510566213	*****	Шинэчлэх		Багш, түүх-нийгэм ...	Багш сонгох
ES3510566214	*****	Шинэчлэх			Багш сонгох
ES3510566217	*****	Шинэчлэх			Багш сонгох
ES3510588596	*****	Шинэчлэх			Багш сонгох
ES3510588597	*****	Шинэчлэх		Багш, хятад хэлний	Багш сонгох

Хэрэглэгчийн эрх цонхны **багшийн эрх** таб дээр дарахад багшид олгох хэрэглэгчийн эрхийн жагсаалт гарна. Хэрэглэгчийн эрхийн мөрийн **багш сонгох** дээр дарснаар дараах цонх нээгдэнэ.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

Албан тушаал

Нэр

Овог

Хайх Цэвэрлэх

	DisplayName	Сургуулийн нэр	Багшийн төрөл	Албан тушаал	Овог	Нэр
Сонгох	Б	Бага Ангийн Заах А...	Бага ангийн үндсэн ...	Бага боловсролын ...	Б	С
Сонгох	М	Дунд Ангийн Заах А...	Дунд ангийн үндсэн...	Багш, биеийн тами...	М	Д
Сонгох	Ц	Дунд Ангийн Заах А...	Дунд ангийн үндсэн...	Багш, физикийн	Ц	Б
Сонгох	Н	Дунд Ангийн Заах А...	Дунд ангийн үндсэн...	Багш, хөгжмийн /ЕБС/	Н	Б
Сонгох	П	Дунд Ангийн Заах А...	Дунд ангийн цагийн...	Багш, монгол хэл, у...	П	З

Хайх товч дээр дарснаар таны БУС-д багш нэмэх үйлдлээр оруулсан багшийн мэдээлэл хүснэгт хэлбэрээр дээрхи зурагт харагдаж байгаачлан гарна. Багшийн нэрийн өмнөх **сонгох** товчийг дарснаар **хэрэглэгчийн эрх** гэсэн цонх руу шилжинэ.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

119 ES3310

Хэрэглэгчийн эрх | Багийн эрх | Шалгалтын эрх

Шинэчлэх

Хэрэглэгчийн нэр	Нууц үг		Шинэчлэх	Нэр	Овог	Албан тушаал	
ES351055	*****	👁	Шинэчлэх	А	Е	Багш, англи хэлний	Багш сонгох
ES351055	*****	👁	Шинэчлэх	У	Б	Багш, бага ангийн /...	Багш сонгох
ES351056	*****	👁	Шинэчлэх	Э	Б	Багш, бага ангийн /...	Багш сонгох
ES351056	*****	👁	Шинэчлэх	С	Д	Багш, бага ангийн /...	Багш сонгох

Шинэчлэх товчийг дарснаар сонгосон багш хэрэглэгчийн нэрийн сонгогдсон хүснэгтэд бөглөгдөж гарна. Хэрэглэгчийн нэр дэх харгалзах нүдний зураг дээр дарж нууц үгийг нээж хариуцсан АУБ-д (хэрэглэгчийн нэр, нууц үг) өгнө.</p>